



**УВС ЧАЦАРГАНА ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГДИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар *26/01*

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Увс чацаргана” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурал 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот БГД 3 хороо “Эн Би Би Ди” ХХК байр 2 давхар 2 тоотод болов.

Хуралд:

“Увс чацаргана” ХК нь нийт 713499 ширхэг хувьцаатайгаас хуралд хувьцаа эзэмшигч

С.Батболд /188300 ширхэг хувьцааны саналаар/

Д.Эрдэнэ /191109 ширхэг хувьцааны саналаар/

Г.Дэмидбал /191109 ширхэг хувьцааны саналаар/

тус тус өөрийн биеэр оролцов.

Хурал зохион байгуулах комисс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хийж компанийн нийт гаргасан 713499 хувьцаанаас саналын эрхтэй хувьцааны тоог 379454 ширхэг хувьцаагаар тогтоож хурлын ирц 53,1 хувьтай байгааг мэдээлж компанийн тухай хуулийн 69.1 заасны дагуу хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлэхийг тооллогын комисс зөвшөөрөв.

Хурал 13 цаг 20 минутанд эхлэв.

Тооллогын комисс ирцийг танилцуулж хурлыг нээхийг хурлын даргад мэдэгдэж компанийн ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай тогтоолд хурлыг удирдах даргаар Д. Эрдэнийг томилсон иймээс хурлын дарга хурлыг эхлүүлнэ үү.

Ингээд хурлын дарга Д.Эрдэнэ байраа эзлэв.

- За та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. Миний бие Увс чацаргана ХК-ийн ТУЗ дарга хувьцаа эзэмшигч Эрдэнэ гэдэг Ингээд хуралаа эхлэх үү. Хурлын дэгийг юуны өмнө уншиж танилцуулая.

Энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.

Үүнд:

0. Компанийн 2021 оны үйл ажилагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлт;
1. Ногдол ашиг хувиарлахгүй талаар ТУЗ гаргасан шийдвэрийг танилцуулах:

2. Бусад асуудал

СОНССОН НЬ 1:

Хурлын хэлэлцэх асуудлын дагуу 2020 оны үйл ажиллагааны тайлан болон компанийн товч танилцуулгыг уншиж танилцуулав. /Presentation/ ээр танилцуулга хийв.

“Увс чацаргана” ХК нь 1978 оноос хойш чацарганы үйлдвэрлэл эрхлэхээр байгуулагдсан бөгөөд 1988 он гэхэд нийт 480 га талбайд 500,000 ширхэг чацарганы модтой, бүрэн механикжсан усалгааны систем, үерийн далангийн байгууламжтай, нийт 300-аад ажиллагсадтай эрдэм шинжилгээний туршилт судалгааны төв болон өргөжсөн юм.

Монгол улс зах зээлийн нийгэмд шилжсэн 1990-ээд оны үед тус байгууллага нь бусад аж ахуйн нэгж, үйлдвэрүүдийн нэгэн адил зах зээлийн болон санхүүгийн хямралд өртөж их хэмжээгээр сүйдсэн юм.

Манай компани нь дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Үүнд:

1. Чацарганы аж ахуй
2. Мод үржүүлэг
3. Төмс, хүнсний ногоо тариалалт
4. Загас үржүүлэг, худалдаа зэрэг салбарт бизнесийн үйл ажиллагаа явуулж байна.

Шинэчлэгдсэн компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь чацарганы аж ахуй юм.

СОНССОН НЬ:

Хурлын дарга :Д Эрдэнэ Компанийн үйл ажиллагаа доголдож байна. малд гоц халдвартай өвчин байдаг шиг ургамалд хүртэл байдаг юм байна манай нөгөө нэг чацарганын моднууд өвчлөөд юу ч гүй сүйдсэн 500 га газар тарьсан байсан бүгдийн устгалд оруулаад үндсээр нь авч хаясан мөн тариалан дэмжих сангаас 200 саяын усалгааны системийг өөрийн хөрөнгөөр тавьсан оруулсан хөрөнгө одоо болтол авч чадаагүй .

Дахиад хөрөнгө оруулалт хийгээд 100,000 чацарганын мод тариалсан юм тэгээд нөгөө хуучин өвчин мөөгөнцөр ургамлын хачиг шимэгч хэчнээн хор цацаад нэмэргүй тэр нь бас шалтгаантай юм байна лээ манай талбаатай залгаа битүү шигүү торлог маягийн бургас байдаг хүн орохын аргагүй бид хар хэчнээн мянга хор цацаад хамгаалаад байсан ч гэсэн тэндээсээ орж ирээд байдаг, хэцүү тэгээд нөгөө моднууд чинь дахиад сүйдсэн чацаргана, үхрийн нүд мод үржүүлэг хийж байсан тэгээд тухайн үед эдийн засагийн асуудалд ороод зогссон одоо бол үсрээд компанид одоогоор 10,000 ширхэг мод байгаа байх бид нар жимсээ хураадаггүй юм, юу гэхээр 1кг чацарганыг 3,000 төгрөгөөр хураадаг тэрийгээ 3,500 төгрөгөөр зарахаар ямарч ашиггүй.

Хувьцаа эзэмшигч Г.Дэмидбал: Компанийн 328,000,000 үнэлгээтэй байна.

Хурлын дарга :Д Эрдэнэ: Тэр зүгээр хувьцааны л үнэлгээ

Хувьцаа эзэмшигч Г.Дэмидбал: Тэгж хараад ногдол ашиг тараахгүй байх тухай хэлэлцэнэ гэхээр би орсон орлогоо буцаагаад эздийн өмчдөө шингээж байгаа юм байна гэж бодсон байхгүй юу 328ийн үнэлгээтэй болохлээр ойрын хугацаандаа нугарч болох юм байна гэж бодсон

Хурлын дарга :Д Эрдэнэ: Ашиг, байхгүй, газрын орчин үеийн үнэлгээгээр өндөр үнэлсэн байна лээ

Хувьцаа эзэмшигч Г.Дэмидбал: 340 га эзэмшдэг үү?

Хурлын дарга :Д Эрдэнэ: Эзэмших хуучин 500га газартай байсан. Үе үеийн засаг дарга нарт булаалгасан.

Хурлын дарга :Д Эрдэнэ: ХХК болох сонирхолтой байгаа гэвч болж чаддаггүй ,газраа алдах магадлалтай , хөрөнгөө оруулалт хийхэд ашиггүй.

Хувьцаа эзэмшигч Г.Дэмидбал: Та ХК-даа ХО хийх боломжтой жимст Увс ХК-г Ард авсан аваад ХО хөгжүүлсэн.

Хурлын дарга :Д Эрдэнэ: Хэтийн төлөв нь юу вэ Чацаргана тариалах ашиггүй 1-2 га-д өрхийн хэмжээнд тариалбал ашигтай байна. Аж ахуйн хэлбэрээр маш их хэмжээний явбал маш их хэмжээний хөрөнгө оруулалт техник технологийн дэвшил хийх болж ажилтай байгаад байна.

Манай энэ талбай дээрээ арай өөр чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2-3 төсөл боловсруулсан байгаа, эрчимжсэн мал аж ахуй, малын тэжээлийн ургамал, эмийн ургамал, махны чиглэлийн үхэр , гэх мэт төслүүд байгаа.

Хувьцаа эзэмшигч Г.Дэмидбал: Би сарынхаа цалингаасаа хувьцаа авч байгаа.

Хурлын дарга :Д Эрдэнэ: Чи ямар мэргэжилтэй вэ ?

Хувьцаа эзэмшигч Г.Дэмидбал: Багш туслах багших сургуульд маркетинг чиглэлээр.

Хурлын дарга :Д Эрдэнэ: Манай төсөл дээр хамтран ажиллахад татгалзах зүйлгүй шүү. Цаг үеийн таатай байдлыг

хүлээж байгаа компани.

Хурлын дарга :Д Эрдэнэ: Аймагаа махаар хангаад байх хэмжээний байхад болно доо.Том биш тэжээл таривал 5-10 төрлийн тэжээлийн ургамал судалж байгаа. Хөрөнгө оруулалт ын тухайд газраа барьцаалж зээл авах боломжтой , нэмж хувьцаа гаргах шаардлага байхгүй зардал өндөргарна. Одоо компанид үлпсэн зүйл гэвэл газар байна, туршлагатай хэдэн тариаланч цэцэрлэгжүүлэгч нар байна даа.

СОНССОН НЬ:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга А.Ариунсайн Компанийн тухай хуульд заасаны дагуу төлөөлөн удирдах зөвлөл санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногын дотор ноогдол ашиг хувиарлах тухай шийдвэрийг Туз гаргана гэж заасаны дагуу ТУЗ хуралдаж хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг хувиарлах боломжгүй гэж үзсэн.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:


1. Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг баталсугай.

2. Компани 2021 оны ногдол ациг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн ТУЗ-ийн шийдвэрийг зөвшөөрсүгэй.
3. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд даалгасугай.

Хурал 14.45-д өндөрлөв.

ХУРАЛ УДИРДСАН:

ХУРЛЫН ДАРГА

 /Д.ЭРДЭНЭ/

ПРОТОКОЛ БИЧСЭН:

 /АРИУНСАЙН/